



ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ЭДИЙН БУС ХОХИРЛЫГ НӨХӨН ТӨЛӨХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

СУУРИН ДҮН ШИНЖИЛГЭЭ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

1. Монгол Улсад эдийн бус гэм хорыг нөхөн төлүүлж буй практик

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт хохирогч гэж нэр төр, алдар хүнд, санаа сэтгэл, бие эрхтэн, эд хөрөнгийн талаар хохирол хүлээсэн этгээдийг хэлнэ гэж заасан. Нэр төр, алдар хүнд, сэтгэл санаа, бие эрхтний хохирол нь эдийн засгийн эргэлтэд арилжааны зүйл болдоггүй ба эдийн бус хохиролд хамаарна. Энэ хохирлын хэмжээг хэрхэн яаж тооцож, барагдуулах талаарх эрх зүйн зохицуулалт дутмаг байгаагаас гэмт хэргийн улмаас хохирсон иргэд өөрт учирсан хохирлоо бодитой, бүрэн дүүрэн төлүүлэх эрхээ эдэлж чадахгүй, хохирсон хэвээр үлдэж байна.

Шүүхийн практикт гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шийдвэрлэхдээ зөвхөн нотлох баримтад тулгуурлаж байгаа тул эмчилгээний зардал, оршуулгын зардал, тээврийн зардлын баримт, түүнчлэн аймаг, дүүргийн засаг даргын тамгын газрын санхүүгийн хэлтсийн үнэлгээний комиссын үнэлгээ зэргийг харгалзан хохирлыг тогтоож, нөхөн төлүүлэх шийдвэрийг гаргаж байна. Өөрөөр хэлбэл энэхүү зардалд эд хөрөнгийн хохирол хамаарах бөгөөд эдийн бус хохирол тооцогдохгүй орхигддог. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 42 дугаар зүйлийн 42.3.9 дэх хэсэгт заасны дагуу хохирогч нь гэмт хэргийн улмаас өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй байдаг. Гэтэл хохирогч энэхүү эрхээ эдэлж чадахгүй байгаа нь эрх зүйн зохицуулалт хангалтгүй байгааг илтгэж байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын асуудлыг эрүүгийн хэрэгт хянан шийдвэрлэхдээ шүүх Иргэний хуулийн гэм хор учруулснаас үүсэх үүргийг зохицуулсан холбогдох зүйл, заалтыг баримтална.

Иргэний хуулийн 228 дугаар зүйлийн 228.1 дэх хэсэгт “Гэм хорыг арилгах үүрэг бүхий этгээд нөгөө талын зөрчигдсэн эрхийг гэм хор учруулахаас өмнөх байдалд сэргээх үүрэгтэй. Зөрчигдсэн эрхийг сэргээх боломжгүй, эсхүл харьцангуй их зардал гарахаар бол гэм хорыг мөнгөөр нөхөн төлж болно.” гэж заасан ба эдийн бус гэм хорыг арилгуулахаар хохирогчийн шаардах эрхийг хуульчилсан. Эдийн бус хохирол нь материаллаг бус бүх хохирлыг багтааж байдаг. Иргэний хуулийн тайлбарт дурдахдаа Бие эрхтний болон сэтгэцийн хохирол, амьдралын баяр баясгалан байхгүй болох, хийлгэх ёстой хүнд мэс заслын улмаас үүссэн нервийн ачаалал гэх мэт хамаарна¹.

Гэхдээ Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2 дахь хэсэгт “Гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлнө.” гэсэн нь хохирол барагдуулах үйл ажиллагааг явцууруулж байна. Үүнийг Улсын дээд шүүхийн 2009 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 15 дугаар тогтоолын 6.2.4-т тайлбарлахдаа “Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2-т эдийн бус гэм хорыг зөвхөн хуульд тусгайлан заасан тохиолдолд мөнгөөр нөхөн төлөхөөр заасан ба хүний амь нас, бие эрхтэн, өвчин, зовиур шаналал, сэтгэл санааны байдал зэрэг эдийн бус хохирлыг үнэлэх хуулийн зохицуулалт байхгүй нөхцөлд мөнгөөр нөхөн төлүүлж болохгүй.” гэж заасан. Үүнийг иргэний хуулийн тайлбарт дурдахдаа “... энэ нөхөн төлбөрийг харин хуульд илүү тодорхой тусгасан тохиолдолд шаардаж болно” гээд Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийн 511.1 дэх хэсгийн заалтыг жишээ болгожээ.

¹ Ё.Кают, Э.Шпанглер нар. Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар 2010 он. 458-р тал

Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийн 511.1 дэх хэсэгт “Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийгээ бодит байдалд нийцэж байгааг нотолж чадахгүй бол эд хөрөнгийн хохирол арилгасныг үл харгалзан, эдийн бус гэм хорыг мөнгөн болон бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээнэ.” гэсэн ба үүнд дурдсан гэм хорыг мөнгөн хэлбэрээр арилгах зохицуулалт хийгдсэн байна.


Улмаар Иргэний хуулийн 21, 511 дүгээр зүйлд заасан эдийн бус гэм хорыг мөнгөн болон бусад хэлбэрээр арилгаж болохыг Улсын дээд шүүх тогтоолоороо тайлбарласан байна.

Гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан тохиолдолд түүнийг оршуулахтай холбоотой зардал болон гэм хор учруулсны төлбөрийн хэмжээг Иргэний хуулийн 508 дугаар зүйлийн 508.3 дахь хэсэгт зааснаар тогтоож байна. Иргэний хуулийн 508 дугаар зүйлийн 508.3 дахь хэсэгт “Хохирогч нас барсан бол түүнийг оршуулахтай холбогдсон зайлшгүй зардал болон гэм хор учруулсны төлбөрийг түүний өв залгамжлагч шаардах эрхтэй.” гэж заасан ч Дээд шүүхийн өмнөх тайлбарт дурдсанаар эдийн бус хохирлыг үнэлэх хуулийн зохицуулалт байхгүй нөхцөлд мөнгөөр нөхөн төлүүлж болохгүй хэвээр байна.

Улмаар өмнө дурдсан Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт заасан хохирогчид учирсан санаа сэтгэл, бие эрхтний хохирлыг хэрхэн нөхөн төлөх тухайд Иргэний хууль болон бусад хуульд тусгайлан зохицуулаагүй гэж үзэх үндэслэлтэй байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нотлогдоогүй хэсгийг барагдуулуулахаар иргэний журмаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй болохыг шүүхийн тогтоолд дурддаг боловч иргэний журмаар шүүхэд нэхэмжлэл гаргахад санаа сэтгэл, бие эрхтний хохирлыг мөнгөөр үнэлэх зохицуулалтгүйн улмаас хохирлоо нэхэмжлэх эрхгүй болдог.

Тиймээс эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, олон улсын болон гадаад улс орны эрх зүйн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэх шаардлага зүй ёсоор урган гарч байна.



2. Европын зарим улсад эдийн бус хохирлыг нөхөн төлүүлж буй практик

Европын ихэнх орнууд хувь хүнд учирсан хохирлыг нөхөн төлөх хоёр ялгаатай аргыг хэрэглэж байна. Зарим улсууд тодорхой өгөгдлийн бүдүүвч ашиглан мөнгөн хэлбэрээр эдийн бус хохирлыг нөхөн төлүүлж байна.² Бусад улсад шүүгчийн үзэмжээр эрх зүйн практик дээр тулгуурлан хохирлыг барагдуулж байна.

Эхнийхийг нь “нөхөн төлбөрийн хүснэгттэй улсууд” гэж нэрлэж болно. Испани, Франц, Бельги, Итали, Чех улсууд энэ ангилалд багтаж байна. Удаахь нь Герман, Швейцари, Австри, Голланд, Польш зэрэг “жишгийн эрх зүйт улсууд” юм. Нэн ялангуяа Испани, Чех улсууд нөхөн төлбөрийн хүснэгтийг хуульчилсан бол Бельги, Франц, Итали улсуудад шүүхүүд хүснэгтийн системийг бий болгожээ.

2.1 Оросын Холбооны Улс

Тус улсад сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийг шүүхийн журмаар олгодог байна. Нөхөн төлбөрийг олгохдоо тухайн буруутай үйлдэл үйлдсэн этгээдээс нэхэмжилдэг.

Эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэхэд Иргэний хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон Эрделевскийн хүснэгтийг ашиглаж байна.

ОХУ-ын Иргэний хуулийн 151 дүгээр зүйлд “Хэрвээ тухайн иргэнд эдийн бус хохирол (бие эрхтэний эсвэл сэтгэл санааны шаналал) учруулсан эсвэл хуульд заасан бусад тохиолдолд шүүх гэмт этгээдэд учруулсан эдийн бус хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх тухай шийдвэр гаргаж болно.” гэж заасан.

Нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо шүүх гэмт этгээдийн гэм буруу болон бусад нөхцөл байдлыг анхаарч авч үзнэ. Түүнчлэн шүүх учруулсан бие эрхтний болон сэтгэл санааны хохирлын хэмжээ болон тухайн хувь хүний онцлогийг харгалзан үзэх ёстой.

Мөн тус хуулийн 152 дугаар зүйлд “Тухайн иргэний эсрэг худал хуурмаг, нэр хүнд, алдар хүндэд халдсан тохиолдолд энэхүү мэдээллийг худал хуурмаг болохыг тогтоолгохын зэрэгцээ энэхүү сэтгэл санааны хохирол барагдуулахыг шаардах эрхтэй.”, 1101 дүгээр зүйлд “Эдийн бус хохирлын нөхөн төлбөрийг мөнгөн хэлбэрээр олгоно. Эдийн бус хохирлын нөхөн төлбөрийн хэмжээг шүүх тогтоох бөгөөд хохирогчид үчирсан гэм хорын хэмжээ (бие эрхтэн эсвэл сэтгэл санааны), гэмт үйлдэлийн буруутай байдлыг үндэслэн тогтооно. Нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо зүй ёсны шаардлага болон шудрага байдалд нийцсэн хэмжээ тогтооно.” гэж заасан нь оновчтой зохицуулалт болжээ.

Тус улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд “Энэхүү хууль болон бусад хуульд заасны дагуу ажилтан нь сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй.”, 237 дугаар зүйлд “Ажил олгогчийн буруутай үйлдэл эсвэл эс үйлдлээс ажилтанд учирсан сэтгэл санааны хохирлыг мөнгөн хэлбэрээр хөдөлмөрийн гэрээнд заасан хэмжээгээр олгоно. Маргаан үүсэн тохиолдолд сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг шүүхийн журмаар шийдвэрлэнэ.” гэж заасан байдаг.

² Holger Backu, Indemnity law in Germany, Belgium and the Netherlands

ОХУ-ын одоогийн шүүхийн практикт хууль тогтоомжоор зохицуулагдсан, эсхүл ОХУ-ын дээд шүүхээс удирдамж болгосон сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх хэмжээг тогтоох аргачлал байхгүй хэдий ч зарим аргачлалыг шүүхийн практикт хэрэглэдэг байна. Тухайлбал, А.М.Эрделевскийн зохиосон хүснэгтийг³ шүүхийн практикт хэрэглэж байна.

Сэтгэл санааны нөхөн төлбөрийн хэмжээг тогтооход $D=d*fv*i*c*(1-fs)$ томъёог ашиглахыг эрдэмтэн судлаач Эрделевский санал болгож байна.

Хүснэгт 1

Гэмт үйлдэл	Сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийн хэмжээ	
	Нэгжид ноогдох дүн	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ
Хүний эрүүл мэндэд хүнд гэмтэл учруулах	0,8	576
Дээрх үйлдэл нь тарчлаан зовоож онц хэрцгийгээр үйлдэгдсэн бол	1	720
Хүний эрүүл мэндэд хүндэвтэр гэмтэл учруулах	0,3	216
Дээрх үйлдэл нь тарчлаан зовоож, хэрцгийгээр үйлдэгдсэн бол	0,5	360
Хүний эрүүл мэндэд хөнгөн гэмтэл учруулсан бол	0,03	24

$$D=d*fv*i*c*(1-fs)$$

- D –Сэтгэл санааны хохирлын нийт дүн;
- d - Сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийн хэмжээ;
- fv – Гэмт этгээдийн үйлдсэн гэм хорын хэмжээ. Гэм хор нь 0-ээс их 1-ээс бага байна $0 \leq fv \leq 1$;
- i – хувь хүний онцлог. 0-ээс их 2-оос бага $0 \leq i \leq 2$;
- c – анхаарч үзвэл зохих нөхцөл байдал. 0-ээс их 2-оос бага $0 \leq c \leq 2$;
- fs – хохирогчийн гэм буруутай байдал. 0-ээс их 1-ээс бага $0 \leq fs \leq 1$.

Хүснэгт 2

Гэмт хэргийн төрөл	Учирсан хэмээн үзэж байгаа сэтгэл зүйн хохирлын хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр ⁴ тооцох нь
Бусдын эрүүл мэндэд хүнд гэмтэл учруулах	576
Дээрх гэмт хэргийг онц харгис аргаар, тохуурхан даажигнаж, эсхүл зовоон тарчлаан үйлдэх	720

³ Б.Д.Завидов. Моральный вред. 2001., С 21-24

⁴ ОХУ-д хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 1300 рубль байгаа бөгөөд 2007 оны 9 дүгээр сараас 2300 рубль болсон.

Бусдын эрүүл мэндэд хүндэвтэр гэмтэл учруулах	216
Дээрх гэмт хэргийг онц харгис аргаар, тохуурхан даажигнаж, эсхүл зовоон тарчлаан үйлдэх	360
Хүний эрхтэн эсхүл эдийг шилжүүлэн суулгах зорилгоор авахыг албадах	288
Дээрх гэмт хэргийг эрхшээлдээ байгаа эсхүл биеэ хамгаалах чадваргүй хүний тухайд үйлдэх	360
Бэлгийн замын халдварт өвчин халдаах	36
Өвчтөнд тусламж үзүүлээгүйн улмаас эрүүл мэндэд нь хүндэвтэр гэмтэл учруулах	24
Дээрх гэмт хэргийг өвчтөний эрүүл мэндэд хүнд гэмтэл учруулан үйлдэх	216
Хүн хулгайлах	576
Дээрх гэмт хэргийг бие махбодид шаналал учруулан үйлдэх	720
Дээрх гэмт хэргийн улмаас эрүүл мэндэд хүнд эсхүл хүндэвтэр гэмтэл учруулах	1080
Хууль бусаар хорих (1 хоног)	216
Дээрх гэмт хэргийг бие махбодид шаналал учруулан үйлдэх	360
Дээрх гэмт хэргийн улмаас эрүүл мэндэд хүнд эсхүл хүндэвтэр гэмтэл учруулах	576
Сэтгэцийн эмнэлэгт хууль бусаар байрлуулах (1 хоног)	216
Дээрх гэмт хэргийн улмаас эрүүл мэндэд хүнд эсхүл хүндэвтэр гэмтэл учруулах	504
Хуурамч мэдээлэл тараах	24
Дээрх гэмт хэргийг олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан үйлдэх	36
Доромжлох	12
Дээрх гэмт хэргийг олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан үйлдэх	24
Хурьцал үйлдэх, эсхүл бэлгийн шинжтэй хүчирхийллийн бусад үйлдлийг хүчин, заналхийлэл, эсхүл хохирогчийн биеэ хамгаалах чадваргүй байдлыг ашиглан үйлдэх	432
Дээрх гэмт хэргийг алах, эсхүл эрүүл мэндэд хүнд гэмтэл учруулахаар заналхийлэх замаар /хамтад нь/ үйлдэх	720
Дээрх гэмт хэргийн улмаас эрүүл мэндэд хүнд гэмтэл учруулах	1080
Иргэнийг ялгаварлан гадуурхах	144
Зохиогч, зохион бүтээгчийн эд хөрөнгийн бус эрхийг зөрчих	144
Итгэл үнэмшил, шашин шүтэх эрхийг зөрчих	18
Хүүхэд үрчлэх, зохиомол аргаар үр суулгах тухай нууцыг задруулах	144
Хууль бусаар саатуулах	144
Хууль бусаар цагдан хорих (1 хоног)	288

Хууль бусаар эрх чөлөөг хязгаарлах бусад тохиолдол (1 хоног)	7,2
Мэдүүлэг өгөхийг албадах	216
Дээрх гэмт хэргийг хүч хэрэглэн, тохуурхан даажигнаж эсхүл эрүүдэн шүүн үйлдэх	576
Иргэний эрх, эрх чөлөөг бусад аргаар албан тушаалтан, захиргааны байгууллагын хууль бус үйлдэл, шийдвэрээр зөрчих	36
Дээрх гэмт хэргийг их хэмжээний хохирол учруулан үйлдэх	144

Хууль бусаар цагдан хорих, эсхүл өөр байдлаар эрх чөлөөг хязгаарлах нь хууль бусаар ял шийтгэхийн хүнд үр дагаварт орохгүй бөгөөд сэтгэл зүйн хохирол учруулсны төлөө бие даасан хариуцлага хүлээлгэдэг байна.

Хохирлын нөхөн төлбөрийг тухайн буруутай этгээдээс гаргуулдаг. Буруутай этгээдэд нөхөн төлбөр олгох хангалттай хөрөнгө байхгүй бол улсын төсвөөс энэхүү нөхөн төлбөрийг олгодог. Нөхөл төлбөр олгох улсын сангийн хөрөнгийг улсын төсвөөс санхүүжүүлдэг. Жил бүр энэхүү сангийн санхүүжилтийг ОХУ-ын Засгийн газраас баталж өгдөг бөгөөд Улсын төсвийн тухай хуулиар зохицуулдаг.

Украин улсад Эрделевскийн хүснэгтийг Украин улсын шүүх үйл ажиллагаанд удирлага болгох талаар Дээд шүүхээс захирамж гаргаж шүүхийн практикт ашигладаг байна. Хохирлыг ОХУ-тай адил буруутай этгээдээр нөхөн төлүүлдэг байна.

2.2 Литва

Литва улсын Хүчирхийллийн шинжтэй гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай хуульд зааснаар эдийн бус хохиролд олгох нөхөн төлбөрийн дээд хэмжээг доорхи байдлаар тогтоосон байна.

1. 15600 лита буюу 4518 евро – гэмт хэргийн улмаас хүний амь нас хохирсон тохиолдолд
2. 13000 лита буюу 3765 евро – ноцтой гэмтэл учруулсан эсвэл бэлгийн сэдэлтэй холбоотой гэмт хэргийн улмаас учирсан тохиолдолд
3. 10400 лита буюу 3012 евро - ноцтой гэмтэл учруулсан тохиолдолд

Доорх хүчин зүйлс бүгд бүрдсэн тохиолдолд эдийн бус хохирлыг нөхөн төлдөг.

- Шүүхийн шийдвэр гарсан эсвэл хүчирхийллийн шинжтэй гэмт хэрэг үйлдэгдсэн нь тогтоогдсон байх
- Литва улсын нутаг дэвсгэр дээр уг гэмт хэрэг үйлдэгдсэн байх
- Учирсан хохирол нөхөн төлөгдөөгүй байх
- Хохирогч гэмт хэрэг үйлдсэнээс 3 жилийн дотор нөхөн төлбөр олгох тухай хүсэлт гаргасан тохиолдолд /хүндэтгэн үзэх шалтгаантай бол хугацааг дахин харж үзнэ/

Шүүхийн шийдвэрээр гэм буруутай этгээд нь хохирогчид Эрүүгийн байцаан шийтгэх тухай болон Иргэний хуулийн дагуу нөхөн төлбөр олгодог. Хүнд гэмт хэрэг

үйлдсэн гэм буруутанд нөхөн төлбөр олгох хангалттай хөрөнгө байхгүй бол улсын төсвөөс энэхүү нөхөн төлбөрийг олгодог.

Хүчирхийллийн гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах сан нь Хууль Зүй Дотоод Хэргийн яаманд харьяалагддаг бөгөөд тусгай хөтөлбөрөөр санхүүждэг. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах сан нь хуулийн этгээдийн эрхгүй байдаг.

2.3 Бельги

Тус улсад эрүүгийн болон иргэний журмаар хохирол нөхөн төлүүлэх боломж нээлттэй бөгөөд хохирогч аль журмаар хохирлоо нэхэмжлэхийг өөрөө сонгох эрхтэй. Харин эдийн бус хохирлыг эрүү, иргэний журмаар *partie civile* буюу бие даасан оролцогчийн стастустайгаар нэхэмжлэх боломжтой байдаг. Энэ нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хохирлоо нөхөн төлүүлэхээр нэхэмжилж болно гэсэн үг. Гэхдээ энэ нь зөвхөн хохирогчийн хүсэлтээр хэрэгжих ба шүүгч өөрийн санаачилгаар ажиллагаа явуулах эрхгүй.

Харин иргэний журмаар хохирлоо нөхөн төлүүлэхээр нэхэмжилсэн тохиолдолд хэрэв эрүүгийн процесс дуусаагүй байгаа тохиолдолд иргэний шүүх хэргийг шийдвэрлэхийг түр хүлээдэг. Эрүүгийн шүүхээс гаргасан шийдвэрийг иргэний шүүх дагаж мөрдөх зарчим буюу "*le criminel tient le civil en état*" тус улсад үйлчилдэг. Хэрэв эрүүгийн хэргийг шүүхээс хэрэгсэхгүй болгосон тохиолдолд иргэний журмаар хохирлоо нөхөн төлүүлэх боломж тэр хэмжээгээр хумигддаг.

Хохирогч нийтийн сангаас эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэхээр нэхэмжилж болно. Гэхдээ тухайн нөхөн төлбөрийг эрүүгийн хэргийн улмаас бие махбодид нь ямар нэгэн гэмтэл учирсан байгаа тохиолдолд л өгөх боломжтой байдаг.

Жишээ нь, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны эдийн бус хохирлыг дараахь хэлбэрээр нөхөн төлүүлж байна.

Эмнэлэгт хэвтэхэд нэг өдрийн 31 евро
Хөдөлмөрийн чадвараа 100 хувь алдсаны нэг өдрийн 25 евро
Хөдөлмөрийн чадвараа 75 хувь алдсаны нэг өдрийн 19 евро
Хөдөлмөрийн чадвараа 50 хувь алдсаны нэг өдрийн 13 евро

Нэмэлт өвдөлт, шаналал зовиурт мөн нөхөн төлбөр өгнө.

Харин хөдөлмөрийн чадвараа бүрмөсөн алдсан тохиолдолд хохирогчийг насны байдлаар нь ангилан үзэж нөхөн төлбөр олгож байна.

10 ба түүнээс доош настай хүнд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тус бүрт нь 3300 евро

35 ба түүнээс доош настай хүнд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тус бүрт нь 2425 евро

64 ба түүнээс доош настай хүнд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тус бүрт нь 1410 евро.

Хүснэгтэд дурдсан тоо хэмжээ хөдөлшгүй зүйл биш бөгөөд шүүгчийн үнэлэмжээр өөрөөр тогтоогдож болдог байна.

Бусад эдийн бус хохирлын тухайд дараахь хохирлыг нөхөн төлүүлэх боломжтой байдаг.

Гоо сайхны хохиролд 1-7 хүртэлх түвшингээр үнэлж байна.

- 1-р түвшин 250-750 евро
- 4-р түвшин 2250-8700 евро
- 5-р түвшин 8700 евро ба түүнээс дээш
- 7-р түвшин 24800 евро ба түүнээс дээш

Жишээ нь тус улсад нүүрэндээ эдгэшгүй сорви авсан 16 настай хүүхдэд 18600 еврогийн нөхөн төлбөрийг шүүхээс олгосон байна. Түүнчлэн амьдралаас таашаал авах боломжоо алдсаны хохирол, бэлгийн харилцааны хэм алдагдсаны хохирол, сэтгэл санааны тайван бус байдалд оруулсны хохирол зэргийг эдийн бус гэм хорын хэлбэрээр тооцож барагдуулсан байна. Бельгид хохирогчийн ар гэрийнхэнд мөн ёс суртахууны шинжтэй эдийн бус хохирлыг нөхөн барагдуулах тогтолцоо бүрджээ.

- Жишээ нь,
- Эхнэр/нөхрөө алдсан бол 10000 евро
- Эцэг эхээ алдсан бол хүн тус бүрт 17500 евро
- Хүүхдээ алдсан бол 10000 евро

Бельгид хүнд гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох тусгай бүтцийг 1985 оны Хохирогчид нөхөн төлбөр олгох тухай хууль /Victims Compensation Act 1985/-иар бий болгосон. Энэ хуулийн зорилго нь тухайн хохирогчид бүрэн хэмжээгээр нөхөн төлбөр олгохоосоо илүүтэй эрүүгийн болон иргэний байцаан шийтгэх ажиллагаанаас хохирлоо нөхөн төлүүлж чадаагүй, эсвэл бусад хэлбэрийн нөхөн төлбөр, жишээ нь тэтгэвэр тэтгэмж, даатгалын төлбөр гэх мэтийг олж авах боломжгүй хүмүүст санхүүгийн туслалцаа үзүүлэхэд чиглэгдсэн.

2.4 ХБНГУ болон Голланд

Тус хоёр улс дахь хохирол нөхөн төлүүлэх механизм өөр хоорондоо ижил төсөөтэй тул хамтад нь авч үзье. Германы дээд шүүхийн шийдвэрүүдээс үзвэл өвчин шаналал, гэмтэл учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх нь хоёр зорилготой.

1-рт нөхөн төлбөр нь нийгмийн амьдралд оролцох, аз жаргалтай байх боломжоо өвчин шаналлаас болж алдсан хүмүүст чиглэгдэх, 2-рт тухайн гэмтэл нь аль хэсэгт байгаагаас хамаарч мөн нөхөн төлбөрийн хэмжээ ялгаатай. Голландад энэ нь төсөөтэй хэрэглэгдэж байна.

- Голланд дахь шүүхийн шийдвэрүүдээс харвал
- гадаад гэмтэл /хөдөлмөрийн чадвараа алдсан 1 долоо хоногт/ 100-500 евро
 - тархи хөдлөх / хөдөлмөрийн чадвараа алдсан 1 долоо хоногт / 300-1000 евро
 - хүндрэлгүй эмчлэгдэх боломжтойгоор нэг гар хугарсан бол 600-2000 евро
 - хүндрэлгүй эмчлэгдэх боломжтойгоор нэг хөл хугарсан бол 1250-3500 евро
 - тохойноос доошхи нэг гараа алдсан бол 15000-20000 евро

-тохионоос дээшхи нэг гараа алдсан бол	20000-25000 евро
-өвдөгнөөс доошхи нэг хөлөө алдсан бол	15000-20000 евро
-өвдөгнөөс дээшхи нэг хөлөө алдсан бол	20000-25000 евро
-нүд хараагүй болбол нэг нүдэнд	15000-25000 евро
-нуруу сэээрний гэмтлээс болж саажилт үүссэн бол	50000-аас дээш евро
-ДОХ-ын халдвар авсан бол	192000 евро

Жишээ нь Гааг дахь шүүхээс баруун нүдээ алдаж, 2 жилийн турш ажиллах боломжгүй болж, хөдөлмөрийн чадвараа 15 хувь алдсан хүнд 20000 еврогийн нөхөн төлбөр олгох шийдвэр гаргаж байв. Мөн хөлөө 3 см тайруулж, 4, 12, 14 см-ын сорви авч, хичээл сургуулиа хойшлуулсан эмэгтэйд 14500 еврогийн нөхөн төлбөрийг тус шүүхээс олгож байв.

Мөн адил Германд:

- гар хугарсан бол 1000-12500 евро
- хөл хугарсан бол 2500-12500 евро
- нүдээ алдсан бол 12000 ба түүнээс дээш евро, түүнчлэн сар бүрийн тэтгэмж
- хоёр хөл ажиллагаагүй болсон бол 12000 ба түүнээс дээш евро гэх мэт.

Жишээ нь эмнэлгийн буруутай үйл ажиллагаанаас болж сохорсон бага насны хүүхдэд шүүхээс 30000 еврогийн нөхөн төлбөр олгож сар бүр 200 еврогийн тэтгэмж өгөхөөр шийдвэрлэж байв. Мөн Киэлийн тойргийн шүүхээс 3 нас 6 сартай хүүхдийн хөл нь ажиллагаагүй болж байнгын асаргаа, сувилгаа шаардлагатай болсон хохиролд 50000 евро гаргуулж, сар бүр 500 еврогийн тэтгэмж өгөхөөр шийдвэрлэсэн байна.

2.5 Австри

Эрүүгийн хэргийн хохирогч нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хохирол нөхөн төлүүлэхийг шаардах эрхтэй. Тус улсын Эрүүгийн процессын тухай хуулийн 4 дүгээр параграфт зааснаар байцаан шийтгэх ажиллаганы явцад иргэний журмаар тухайн асуудлыг шийдвэрлэж байна. Үүнийг Adhäsionsverfahren буюу иргэний журмаар шийдвэрлэх гэж нэрлэдэг. Гэхдээ эрүүгийн шүүх процессын явцад эрүүгийн болон иргэний хэргийг аль алиныг нь шийдвэрлэдэг байна.

Австрийн Иргэний хуулийн 1325 дугаар зүйлд шаналал, зовиураас үүдэлтэй эдийн бус хохирлыг /Schmerzensgeld/-ыг хэрхэн төлөх талаар заасан. Энд бие мах бодид учруулсан гэмтлийн хохирлыг буруутай этгээдээд нөхөн төлүүлнэ гэж заасан. /§ 1325. Wer jemanden an seinem Körper verletzt, bestreitet die Heilungskosten des Verletzten, ersetzt ihm den entgangenen, oder, wenn der Beschädigte zum Erwerb unfähig wird, auch den künftig entgehenden Verdienst; und bezahlt ihm auf Verlangen überdies ein den erhobenen Umständen angemessenes Schmerzensgeld./

Тус улсын Гэмт хэргийн хохирогчид тусламж үзүүлэх тухай хуульд зааснаар хохирол нөхөн төлүүлэх эрх нь хууль ёсны эрх юм.

2.6 Дани

Тус улсад эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны тухай хууль, журам байдаггүй. Харин Шүүхийн захиргааны тухай хууль буюу Administration of Justice Act

(AJA)-гаар эрүү, иргэний хэрэг маргааныг шийдвэрлэдэг.

Данийн эрх зүйд гэмтэж, бэртсэн хохирогчийг тодорхойлсон ойлголт байдаггүй. Харин сонирхогч этгээд өөрөө хүсэлт гаргаж эрхээ хамгаалуулж болдог.

Хохирогчид нөхөн төлбөр олгох тухай хууль /Victim Compensation Act /-иар уг харилцааг зохицуулж байгаа бөгөөд гэмт хэргийн хохирогчоос мэдүүлэг авах үедээ цагдаа нь тухайн хохирогчийн эрхийг хамгаалах төлөөлөгч томлиуулахаар шүүхэд хүсэлт гаргах үүрэгтэй байдаг. Ихэнх онц хүнд гэмт хэргүүдэд хохирогч нь өөрөө тухайн төлөөлөгчийн туслалцааг авах эрхтэй. Төлөөлөгч нь хохирогчид учирсан хохирлыг барагдуулах, нөхөн төлүүлэхэд туслалцаа үзүүлж ажилладаг.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

3. Нийтлэг эрх зүй /common law/-н системтэй улсуудад эдийн бус хохирлыг нөхөн төлүүлж буй практик

Хэдийгээр шүүгч хэм хэмжээг тогтоодог туршлагатай ч энэхүү тогтолцооны улс орнуудын хувьд хууль тогтоогчийн зүгээс шүүхийн үйл ажиллагаанд удирдлага болгох хэм хэмжээг тогтоосон тохиолдол бий.

3.1 Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс

Тус улсад Нөхөн төлбөрийн тухай хуулийг баталж мөрдөж байна. Тус хуулиар Санхүүгийн үйлчилгээ хариуцсан эрх мэдэл бүхий байгууллагаас баталсан Санхүүгийн үйлчилгээний нөхөн төлбөрийн загварыг ашиглах ба Тусгай шүүхээр асуудлыг шийдвэрлэхээр заасан. Мөн Төрийн нарийн бичгийн даргыг Зохицуулагчаар тохоон томилж, холбогдож журмыг боловсруулах үүрэг өгсөн. Нөхөн төлбөрт зориулсан Нэгдсэн санд хуримтлал үүсгэх хувь хэмжээг тусгайлан заасан байна.

Английн парламентын зүгээс хүн алах, гэрээний үүргээ биелүүлэхгүй байх, бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар хуульчлаагүй боловч эдгээр ойлголтыг тодорхой болгох, удирдлага болгох журмыг хуульчид өмнөх хэрэг тохиолдлоос эшлэн авч байсан онцлогтой. Иймээс нийтлэг эрх зүйн орнуудын шүүгчид шийдвэр гаргахдаа дээд шүүхийн харьяаллын хүрээнд тогтоосон хуулийг “жишиг” болгон ажиллаж, хувийн эрх зүйн орнуудын шүүгчид хуулийн зохицуулалтыг ягштал баримталдагтай адил жишгээ удирдлага болгон шийдвэр гаргаж байна. Лордуудын танхим буюу дээд шүүхээс XVIII зуунд анх удаа өөрийн өмнөх шийдвэрүүдэд тулгуурлан, тусгай зохицуулалтыг хуульд зааж өгсөн ч 1964 онд тус хуульд нэмэлт өөрчлөлт орж, шүүгчид дотоод итгэл үнэмшлээр шийдвэр гаргах боломжийг бүрдүүлсэн. Гэхдээ анхан шатны шүүхүүд нь дээд шүүхийн гаргасан журмыг удирдлага болгосон байна.

3.2 Австрали

Үндсэн хуулийн S51(xxxi) дүгээр зүйлд “Парламент нь энх тайван, дэг журам, үр нөлөөт удирдлагад зориулсан хуулийг батална” гэсэн заалтыг Дээд шүүхээс тайлбарлахдаа Шүүх үүнд анхаарах болно гэжээ. Үүнтэй уялдан шүүхийн зүгээс тухайн хэргийн нөхцөл байдлаас хамаарч, шийдвэр гарах бөгөөд урьд шийдвэрлэсэн хэрэг маргааны шийдвэрийг жишиг болгох боломжтой байна.

3.2 АНУ

11 муж нөхөн төлбөрийн дээд хэмжээний тухай хууль гаргасан (энгийн хохирлын хэмжээг 1-5 дахин ихэсгэх), зарим муж 300,000-5 сая ам.доллар гэж тогтоосон, 13 муж Улсын сан (Treasury), эсвэл Адил тэгш шударга ёсны эвслээс тогтоосон хувь хэмжээг удирдлага болгодог ажээ⁵. Мөн АНУ-ын дээд шүүхээс нөхөн төлбөрийн хэмжээ нь хохирлыг 9 дахин ихэсгэснээс хэтэрч болохгүй гэж тусгайлан шийдвэр гаргасан нь орон даяар хэрэгжих жишээтэй. Гэхдээ хохиролд олгох нөхөн төлбөрийн хэмжээний 75 болон түүнээс дээш хувийг Улсын буюу хандивын сангаас гаргаж чадахгүйд хүрсэн учир дутагдалтай байна. Урьдчилан тооцоогүй зардлын

⁵<http://uscode.house.gov/download/pls/28C171.txt>

хэмжээ буюу хохирлын нөхөн төлбөрийн хувь нь нэхэмжлэгчийн өмгөөлөгчөөс бүрэн хамааралтай байгааг судлаачид мөн онцолдог байна. Ийнхүү задгай байдлыг хууль тогтоогчийн зүгээс хуулиар шийдвэрлэх чиг хандлагатай гэж үзэж болно.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

4. Азийн зарим улсуудад эдийн бус хохирлыг нөхөн төлүүлж буй практик

4.1 Япон

Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яамны дэргэд цөмийн хор хохирлын нөхөн төлбөрт зориулсан хураамжийг цөмийн талбар буюу онгоц бүрт 120 тэрбум иен байхаар тооцдог ба гадаад улсын зүгээс цөмийн хөлөг онгоц ирэх бол нэг бүрт нь 36 тэрбум иен нөхөн төлбөрт байршуулахыг шаарддаг байна. Нөхөн төлбөрт зориулсан хураамжаа Хууль зүйн асуудал хариуцсан товчоо буюу Тойргийн хууль зүйн асуудал хариуцсан товчоонд шилжүүлж, Яамны зөвшөөрөлтэйгээр хохирол учирсан талаар гомдол гаргасан этгээдэд олгоно. Нөхөн төлбөр олгох журмыг Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яам болон Хууль зүйн яам хамтарч гаргадаг онцлогтой. Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яамны дэргэд Цөмийн хохиролтой холбоотой нөхөн төлбөрийн асуудал эрхэлсэн Маргаан таслах хороо ажиллахаар тус тус хуульчилжээ. Энэ хуультай холбогдуулан Ажлын байран дээр ослын даатгалын тухай хуульд (the Insurance Act for the Compensation of Work Accidents (Act No. 50 of 1947)) нийцүүлэн асуудлыг нарийвчлан зохицуулжээ.

4.2 БНХАУ

Төрийн нөхөн төлбөрийн тухай хуулийн 25, 29 дүгээр зүйлд нөхөн төлбөрийн хэмжээг тооцох хэд хэдэн стандартыг оруулсан бөгөөд амьд явах, эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг харилцан адилгүй үнэлсэн байх жишээтэй.

Төрийн нөхөн төлбөрийн санг орон нутгийн засаг захиргааны нэгжүүдээс бүрдүүлэхээр заасан ба Төрийн зөвлөлөөс тухайн орон нутгийн төрийн мэдлийн санхүүгийн байгууллагыг өөрийн “бодит нөхцөл байдалд” нийцсэн нөхөн төлбөрийн зардлыг төсөвлөж ирүүлэхийг шаарддаг. Улс орон даяарх нөхөн төлбөртэй холбоотой гомдлыг шийдвэрлэхдээ эдгээр орон нутгийн нэгдсэн сангаас татан авалт хийдэг.

Хэдийгээр Төрийн зөвлөлийн зохицуулалт нь орон нутгийн удирдлагуудад нөхөн төлбөртэй гомдлыг шийдвэрлэх нарийвчилсан журам батлахаар чиглүүлдэг, нэг талаас орон нутгийн нөхөн төлбөрийг санг зүй бусаар ашиглахыг хориглосон дүрэм журамтай ч төрийн байгууллагын үйл ажиллагааны улмаас хохирсон гомдолдоо заргаа авч, нөхөн төлбөр авах үндэслэлтэй болсон ч түүнийг нь төлөх нөөцгүй байх нь бий.

Дээрх хуулийн дагуу төрийн байгууллага, албан тушаалтан нөхөн төлбөрийн асуудлыг захиргааны болон эрүүгийн журмаар шийдвэрлэн, хүний эрхийг сэргээх үүрэгтэй. Захиргааны албан хаагч хууль бус үйлдэл гаргавал түүний буруутай үйлдлийн нөхөн төлбөрийг холбогдох удирдах нэгж хариуцах бол эрүүгийн хэрэгт эрүү шүүлт зэрэг үйлдэлд сангаас нөхөн төлбөр олгохоор заасан байна.

Өнөөгийн нөхцөл байдал, бусад улсуудын практикаас харвал гэмт хэргийн улмаас хохирсон хүний санаа сэтгэл, бие эрхтний эдийн бус хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлж арилгах эрх зүйн зохицуулалтыг Иргэний хууль, Эрүүгийн хууль, процессын хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах замаар бий болгох, шүүх хэргийг шийдвэрлэхдээ баримтлах эдийн бус хохирлын хэмжээг тооцох аргачлалыг батлан мөрдүүлэх шаардлагатай байна.

2013.01.23

UIH.MN
СУДАЛГААНЫ САН